МЭДЭЭ · 2024 оны 5-р сарын 13

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ МАХНЫ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАЗРУУДЫГ ШАЛГАЖ, ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙГ АРИЛГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВЧЭЭ



Сонгинохайрхан дүүргийн прокурорын газраас тус дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн алба хаагчид болон Сонгинохайрхан дүүрэг дэх Мал эмнэлгийн улсын байцаагч нартай хамтран тус дүүрэгт махны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг газруудад холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авчээ.

Тус шалгалтаар мал төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл, худалдааны 10 орчим аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай танилцахад, мал эмнэлгийн дүгнэлт гаргуулаагүй, ариутгал болон харуул хамгаалалтын гэрээ байгуулаагүй, хөдөлмөр хамгааллын сургалт хийгээгүй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилга өгөөгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Тиймээс зөрчлийг арилгуулахаар нэр бүхий 3 газарт прокурорын мэдэгдэл хүргүүлж, зохих зөвшөөрөлгүй ажиллаж байсан “ЗС” компанийн үйл ажиллагааг зогсоон, лац тавин битүүмжилжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1181